

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

*1996 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр
Улаанбаатар хот*

СОЁЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад соёлын үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн үндэс, соёлын үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүрэг, соёлын удирдлагын тогтолцоо, соёлын ажилтны нийгмийн халамж баталгаа, соёлын байгууллагын өмч, санхүүжилтийн зарчим, арга хэлбэрийг тогтоож, уг үйл ажиллагаанд оролцогчдын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Монгол Улсын соёлын хууль тогтоомж

1. Монгол Улсын соёлын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.
/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

Энэ хуульд хэрэглэсэн дор дурдсан нэр томьёог дараахь утгаар ойлгоно:

1/ "соёлын үйл ажиллагаа" гэдэгт соёлын үнэт зүйлийг бүтээх, эзэмших, ашиглах, хадгалж хамгаалах, судлах, түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой дараахь үйл ажиллагаа хамаарна:

а/ уран зохиол, хөгжим, дүрслэх урлаг, театр, цирк, киноны урлаг, уран барилга, дизайн зэрэг урлагийн бүх төрлийн бүтээл туурвих, нийтийн хүртээл болгох;

б/ соёлын үнэт зүйлийг бүтээх, хадгалж хамгаалах, нийтийн хүртээл болгоход чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

в/ монгол үндэстэн болон угсаатан, ястны хэл, аялгуу, аман болон бичгийн соёлыг хадгалж хамгаалах, сэргээн хөгжүүлэх;

г/ иргэдийн соёлын ерөнхий төвшинг дээшлүүлэх, уран сайхан-гоо зүйн боловсрол, хүмүүжил олгох;

д/ олон нийтийн мэдээллийн хэрэгслээр соёлын үйл ажиллагаа явуулах;

е/ соёл судлалыг хөгжүүлэх;

ж/ соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх.

2/ "соёлын үнэт зүйл" гэдэгт гоо сайхны үзэл баримтлал, эх хэл, бичиг үсэг, аман аялгуу, уламжлалт технологи, газар усны нэр, зан заншил, бэлгэ тэмдэг, ардын аман зохиол, ном, судар, шашдир, угийн бичиг, им, тамга, хадны зураг, бичээс, гар урлал, урлагийн бүх төрлийн болон соёл судлалын бүтээл, судалгааны арга барил хамаарна;

3/ "соёлын байгууллага" гэдэгт энэ хуулийн дагуу соёлын үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж хамаарна;

4 / "соёлын ажилтан" гэж бүх төрлийн уран бүтээлийг бүтээн туурвих, соёлын үнэт зүйлийг түгээн дэлгэрүүлэх, хадгалан хамгаалах, сэргээн засварлах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд дагнан эрхэлж байгаа иргэнийг хэлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Соёлын талаархи иргэний эрх, үүрэг

4 дүгээр зүйл. Соёлын талаархи иргэний эрх

1. Монгол Улсын иргэн соёлын талаар дараахь эрх эдэлнэ:

1/ үндэсний болон дэлхий нийтийн соёлын үнэт зүйлтэй танилцах, соёлын үйл ажиллагаа явуулах, тэдгээрийн үр шимийг хүртэх;

2/ уран бүтээлийн сэдэв, төрөл зүйл, арга барил, дэг сургууль, урсгал чиглэлийг чөлөөтэй сонгон авах, үүдэл санаа, ур чадварынхаа нууцыг хамгаалуулах ;

3/ Монгол улсын болон тухайн орны хууль тогтоомжоор хориглосноос бусад соёлын үйл ажиллагааг гадаадад явуулах;

4/ эх хэл, бичиг үсэг, ёс заншил, түүх, соёлын уламжлалыг өвлөн хөгжүүлэх;

5/ соёлын үйл ажиллагаа явуулах эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах зорилгоор уран бүтээлийн эвлэл, холбоо, нийгэмлэг байгуулах, тэдгээрт эвлэлдэн нэгдэх.

5 дугаар зүйл. Соёлын талаархи иргэний үүрэг

/Энэ зүйлийн гарчигт 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

Монгол Улсын иргэн соёлын талаар дараахь үүрэг хүлээнэ:
/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

1/ түүх, соёлын уламжлалыг хамгаалж хөгжүүлэх;

2/ эх хэл, бичиг үсгээ судлах, өвлөх, өвлүүлэх;

3/ гэр бүлийн соёл, хүмүүжлийн уламжлалыг дээдлэн хөгжүүлж, удам угсаагаа мэдэх, угийн бичиг хөтлөх;

4/ соёлын үнэт зүйлийг элдэв халдлагаас сэрэмжлэн хамгаалах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Соёлын байгууллага

6 дугаар зүйл. Соёлын байгууллагын ангилал

1. Соёлын байгууллага нь өмчийн хэлбэрээс үл хамааран улс болон орон нутгийн чанартай гэсэн ангилалтай байна.

2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж харгалзахгүйгээр бүх нийтэд соёл, урлагаар үйлчлэх зорилго бүхий төрийн өмчийн байгууллага нь мэргэжлийн соёл, урлагийн төв байгууллагад тооцогдоно.

/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

3. Хэд хэдэн аймгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх үүрэг бүхий бүс нутгийн соёлын байгууллага байгуулж болно.

4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн болон бүс нутгийн хүн амд соёл урлагаар үйлчлэх зорилго бүхий байгууллага нь орон нутгийн соёлын байгууллагад хамаарна

7 дугаар зүйл. Соёлын байгууллагыг үүсгэн байгуулах

1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хууль тогтоомжийн дагуу ашгийн төлөө болон ашгийн төлөө бус соёлын байгууллага байгуулан ажиллуулж болно.

2. Улсын болон бүс нутгийн байгууллагыг байгуулах шийдвэрийг Засгийн газар гаргана.

/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3. Төрийн өмчийн бүс нутгийнхаас бусад орон нутгийн соёлын байгууллагыг байгуулах шийдвэрийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гаргана. Шийдвэр гаргахдаа аймаг, нийслэлийн Засаг дарга соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай, сум, дүүргийн Засаг дарга аймаг, нийслэлийн Засаг даргатай тус тус зөвшилцөнө.

4. Соёлын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.

8 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох

/Энэ зүйлийг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

9 дүгээр зүйл. Улсын бүртгэлд бүртгэх

1. Соёлын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэнэ.

*/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/
[/Энэ хэсгийг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)*

2. */Энэ хэсгийг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

3. */Энэ хэсгийг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

10 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

/Энэ зүйлийг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

11 дүгээр зүйл. Соёлын байгууллага татан буугдах

1. Соёлын байгууллага дор дурдсан нөхцөлд татан буугдана:

1/ */Энэ заалтыг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/*

2/ татан буулгах тухай үүсгэн байгуулагчийн, эсхүл шүүхийн шийдвэр гарсан.

2. Соёлын байгууллага татан буугдсанаас хойш 45 хоногийн дотор энэ тухай бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

3. Хууль тогтоомжид заасны дагуу татан буулгах ажиллагаа хийгдэж, бүртгэх байгууллага бүртгэлээс хассанаар соёлын байгууллагыг татан буугдсанд тооцно.

4. Соёлын байгууллага татан буугдсантай холбогдож үүссэн маргааныг шүүх шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Соёлын удирдлага, зохицуулалт

12 дугаар зүйл. Соёлын удирдлагын тогтолцоо

Соёлын удирдлагын тогтолцоо нь соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Соёл, урлагийн хороо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн болон соёлын байгууллагын удирдлагаас бүрдэнэ.

[/Энэ зүйлд 2008 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/](#)

13 дугаар зүйл. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

1. Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхтэй байна:

~~1/ төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах;~~

[/Энэ заалтыг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

2/ хууль тогтоомжийн хүрээнд түүнийг хэрэгжүүлэх зорилгоор соёлын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг батлан гаргах;

3/ Энэ заалтыг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

4/ улсын чанартай болон орон нутгийн төрийн өмчийн соёлын байгууллагын оновчтой сүлжээ, бүтцийг бий болгож мөрдүүлэх;

~~5/ соёлын байгууллагыг санхүүжүүлэх асуудлыг шийдвэрлэх;~~
[/Энэ заалтад 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/](#)

~~6/ түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах, үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх;~~

~~7/ эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, уран сайхан гоо зүйн хүмүүжил олгох бодлого боловсруулж хэрэгжүүлэх;~~

[/5,6,7 дугаар заалтыг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

8/ олон улсын болон улсын чанартай соёлын арга хэмжээ зохион байгуулах, соёлын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

9/ [/Энэ заалтыг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

10/ дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглох;

~~11/ соёлын тоо бүртгэл гаргаж, дүн шинжилгээ хийх;~~
[/Энэ заалтыг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/](#)

12/ соёлын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, соёлын ажилтны нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлэх;

~~13/ олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр соёлын үйл ажиллагаа явуулахад оролцож;~~

/Энэ заалтыг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

14/ ном, хэвлэл, кино үйлдвэрлэлийг хөгжүүлэх;

15/ соёл судлалыг хөхүүлэн дэмжих.

16/ хүүхдэд уран сайхан, гоо зүйн мэдлэг олгох соёл, урлагийн бүтээлийн зэрэглэл, жагсаалт, хэрэгжүүлэх журмыг тогтоох;

/Энэ заалтыг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

17/ Монгол Улсад шинээр хэвлэгдэн гарч байгаа ном, хэвлэлийн бүтээгдэхүүн тус бүрээс хоёроос доошгүйг шалгаруулалт хийсний үндсэн дээр улс, аймаг, нийслэлийн төв номын санд худалдан авна. Шалгаруулалт хийх, худалдан авах журмыг Засгийн газар тогтооно.

/Энэ заалтыг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 10-т зааснаар соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

3. Соёлын байгууллагын үйл ажиллагаанд тавих хяналтыг соёлын хяналтын асуудал эрхэлсэн мэргэжлийн хяналтын улсын алба хэрэгжүүлнэ.

/Энэ хэсгийг 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хуулиар нэмсэн/

13¹ дүгээр зүйл.Соёл, урлагийн хороо

1.Төрөөс баримтлах соёл, урлагийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах чиг үүрэгтэй Соёл, урлагийн хороо /цаашид “Хороо” гэх/ ажиллана.

2.Хорооны дүрмийг Засгийн газар батална.

3.Хороо нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалах, хамгаалах ажлыг зохицуулах, үндэсний соёл, дизайны уламжлалыг дэмжин хөгжүүлэх;

2/эх хэл, бичиг үсэг, түүх, соёлын мэдлэгийг гүнзгийрүүлэх, уран сайхан-гоо зүйн хүмүүжил олгох бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

3/түүх, соёлын дурсгалт зүйлийг судалж шинжлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, ашиглалт, хамгаалалтад хяналт тавих ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, гадаад, дотоодод үзэсгэлэн гаргах ажлыг зохион байгуулах;

4/утга соёлын өвийн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлэх, хамгаалах, өвлүүлэх, судалж сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах, утга соёлын өвийг өвлөн тээгч билиг авьяастнуудыг судлан тодорхойлж, эрдэм авьяасыг нь хойч үед уламжлуулахад туслан дэмжлэг үзүүлэх;

5/ардын язгуур урлагийн чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

6/дүрслэх урлаг, дизайны чиглэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах;

7/соёлын салбарын боловсон хүчний эрэлт хэрэгцээг судалж, аймаг, нийслэлийн соёл, урлагийн байгууллагыг боловсон хүчнээр хангахад дэмжлэг үзүүлэх;

8/соёл, урлагийн мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

9/соёлын тоо бүртгэл гаргаж, дүн шинжилгээ хийх;

10/хуульд заасан бусад бүрэн эрх.

4.Хороо нь дарга болон орон тооны бус 8 гишүүнээс бүрдэх бөгөөд Хорооны гишүүн нь улсын чанартай соёлын байгууллагын дарга, захирал байна.

5.Хорооны дарга болон гишүүнийг соёл, урлагийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар томилж, чөлөөлнө.

6.Хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 4 жил байх бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

7.Хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд сард хоёроос доошгүй удаа хуралдана. Хуралдааны дэгийг Хорооны дүрмээр зохицуулна.

[/13¹ дүгээр зүйлийг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулиар нэмсэн/](#)

14 дүгээр зүйл. Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын бүрэн эрх

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд соёлын талаар дэвшүүлсэн зорилтын биелэлтийг дүгнэж, түүний хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлж, хяналт тавина.

/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэрт соёлын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ төрийн соёлын бодлого, соёлын хууль тогтоомжийн дагуу соёл урлагийг хөгжүүлэх, иргэдийн соёлын эрэлт хэрэгцээг хангах, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг хөтөлбөртөө тусгаж, хэрэгжүүлэх;

2/ соёлын байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж, хууль тогтоомжид заасны дагуу санхүүжүүлэх, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, ажиллагчдын нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авах;

3/ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

4/ угийн бичиг хөтлөх ажлыг Засгийн газраас баталсан журмын дагуу зохион байгуулах.

3. Баг, хорооны Засаг дарга харьяалах нутаг дэвсгэрийн хүн амын соёлын үйлчилгээг сайжруулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, соёлын талаархи иргэний журамт үүргийн биелэлтийг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

15 дугаар зүйл. Соёлын байгууллагын удирдлага

1. Соёлын байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тусгайлан эрх олгосон соёлын байгууллага хэрэгжүүлнэ.

/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

2. Улсын болон бүс нутгийн чанартай соёлын байгууллагын даргыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн соёлын байгууллагын дарга, захирлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг дарга, сум, дүүргийн соёлын байгууллагын дарга, захирлыг аймаг, нийслэлийн соёлын байгууллагын дарга, захиралтай зөвшилцөн сум, дүүргийн Засаг дарга тус тус томилж, чөлөөлнө.

/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон ба [2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/](#)

3. Төрийн өмчийнхөөс бусад соёлын байгууллагыг үүсгэн байгуулагчийн томилсон дарга удирдана.

4. Улсын болон бүс нутгийн, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн соёлын байгууллагын дарга, захирлыг тухайн салбарын мэргэжилтэй, соёл, урлагийн байгууллагад 3-аас доошгүй жил ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасны дагуу сонгон шалгаруулж томилно.

/Энэ хэсгийг 2006 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуулиар нэмсэн/

ТАВДУГААР БҮЛЭГ

Соёлын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг

16 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагуудын үүрэг

1. Төрийн захиргааны төв байгууллагууд соёлын талаар дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

1/ төрөөс баримтлах соёлын бодлого, соёлын хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан соёлын зорилтыг хэрэгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах;

2/ үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнес, эрх зүй, экологи, ахуйн соёлыг хөгжүүлэх ажлыг соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран буюу дангаар зохион байгуулах.

17 дугаар зүйл. Соёлын байгууллагын нийтлэг үүрэг

Соёлын байгууллагууд дараахь нийтлэг үүрэгтэй байна:

1/ соёлын үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн ур чадвар, үйлчилгээний өндөр түвшинд явуулах;

2/ төсөв, төслийн болон хандивын хөрөнгийг зориулалтаар нь үр ашигтай зарцуулах;

3/ соёлын ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг нь хангах.

18 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

1. Аж ахуйн нэгж, байгууллага соёлын талаар дараахь үүрэгтэй байна:

1/ түүх, соёлын дурсгалт болон соёлын үнэт зүйлсийг хадгалах, хамгаалах;

2/ үйлдвэрлэл, үйлчилгээний соёл, гоо зүй, үндэсний дизайны орчин бүрдүүлж хөгжүүлэх;

3/ ажиллагчдын ерөнхий соёлын түвшинг дээшлүүлэх, урлаг, уран сайхны мэдрэмж, авьяас чадварыг хөгжүүлэх, соёлын үйлчилгээг сайжруулах.

2. Аж ахуйн нэгж, байгууллага соёлын талаар дараахь эрх эдэлнэ:

1/ соёлын салбарт тусламж дэмжлэг үзүүлэх зорилгоор хөрөнгө оруулалт хийх, хандив өргөх;

2/ жил бүрийн орлогын тодорхой хувийг соёлын зориулалтаар зарцуулах;

3/ ажиллагчдын оюуны хэрэгцээг хангах зорилгоор соёлын үйл ажиллагаа эрхлэх нэгж байгуулан ажиллуулах.

19 дүгээр зүйл. Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт

1. Хууль тогтоомжоор хориглоогүй соёлын үйл ажиллагаа явуулахад төрийн болон бусад байгууллага, улс төрийн нам, эвсэл, холбоо, тэдгээрийн албан тушаалтан хөндлөнгөөс оролцох, дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

2. Угсаатан ястны соёлыг ялгаварлан гадуурхах, хавчин хязгаарлахыг хориглоно.

3. Дайн түрэмгийлэл, хүчирхийлэл, садар самууныг сурталчилах, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, соёлд хор хохирол учруулах соёлын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4. Уран бүтээлчийн үүдэл санаа, ур чадварын нууцыг түүний зөвшөөрөлгүйгээр задруулахыг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Соёлын байгууллагын өмч, санхүүжилт, соёлын ажилтанд үзүүлэх нийгмийн баталгаа.

20 дугаар зүйл. Өмч

1. Соёлын байгууллага өмчийн хэлбэрийн хувьд төрийн болон төрийн бус хэлбэртэй байна.

2. Соёлын зориулалтаар ашиглаж байгаа төрийн өмчийн барилга байгууламж, эзэмшил газрыг тухайн байгууллагын үндсэн чиг үүрэгт нь харшлах өөр зориулалтаар бүхэлд нь ашиглуулах, эзэмшүүлэхийг хориглоно.

/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

21 дүгээр зүйл. Соёлын байгууллагын санхүүжилт

1. Соёлын байгууллага нь улсын төсвийн болон бусад хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, хөнгөлөлттэй зээл, соёлын байгууллагын өөрийн орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна.

/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2, 2006 оны 6 дугаар сарын 29 -ний өдрийн хуулиар тус тус өөрчлөлт орсон/

2. Ашгийн төлөө бус улсын болон орон нутгийн байгууллага үйл ажиллагаагаа улсын төсвийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлнэ.

/Энэ хэсэгт 2002 оны 6 дугаар сарын 20, 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

3. Төрийн өмчийнхөөс бусад ашгийн төлөө бус соёлын байгууллагад тодорхой төслийг үндэслэн төрөөс санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлж болно. Төсөл шалгаруулах журмыг Засгийн газар тогтооно.

4. Соёлын зардлыг улсын төсөвт бие даасан зүйл болгож батална.
/Энэ хэсэгт 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

~~5. Соёлыг хөгжүүлэх зорилгоор тусгай зориулалт бүхий санг байгуулан ажиллуулж болно. Уг сангийн ажиллах журмыг Засгийн газар тогтооно.~~
/Энэ хэсгийг 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

6. Соёлыг хөгжүүлэх, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зориулалт бүхий төрийн санд байгууллага, иргэнээс оруулсан хандив, хөрөнгө оруулалтад албан татварын хөнгөлөлт үзүүлэх журмыг хуулиар тогтооно.

7. Соёлын байгууллагыг санхүүжүүлэх нэмэгдэл эх үүсвэр бий болгох зорилгоор Үндэсний хонжворт сугалааг зохион байгуулж болно. Үндэсний хонжворт сугалаа гаргах журмыг Засгийн газар тогтооно.

8. Соёлын үйл ажиллагаанд зориулсан төсвийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.
/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 29 -ний өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

9. Хөгжмийн том хэлбэрийн болон дүрслэх урлаг, кино, ном, хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авч байна. Шилдэг бүтээл шалгаруулан худалдан авах журмыг Засгийн газар тогтооно.
/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

10. Монгол улсын түүхэнд холбогдох онцлог үйл явдал, он дарааллын түүхийн талаархи баримтат кино бүтээх зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

11. Үндэсний уламжлалт, сонгодог болон хүүхдэд зориулсан урлагийн бүтээл, улсын захиалгаар бүтээх уран сайхны болон баримтат кинонд санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар тогтооно.
/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

12. Соёлын байгууллагын улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийг өөрийн үйл ажиллагааны орлого болон байгууллага, иргэдийн хандивын хэмжээгээр багасгаж төлөвлөхийг хориглоно.
/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2003 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/

13. Мэргэжлийн соёл, урлагийн байгууллага нь дэргэдээ судалгаа шинжилгээ, сэргээн засварлалтын газартай байж болно.
/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

22 дугаар зүйл. Соёлын ажилтны нийгмийн баталгаа

1. Соёлын ажилтан нь дараахь нийгмийн баталгаагаар хангагдана:

1/ тэтгэвэрт гарах үед ажиллаж байсан байгууллага нь тэтгэвэр тогтооход баримталсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын нэг жилийн дундажтай тэнцэх хэмжээний тэтгэлгийг тэтгэвэрт гарахад нь нэг удаа олгоно.

2/ хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогийг харгалзан нэмэгдэл цалин, урамшил, эрдмийн зэрэг, цолны болон ур чадварын нэмэгдэл хөлс олгоно;

3/ Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтад заасан соёлын ажилтан ажлын онцлогоос хамаарч мэргэжлийн хөдөлмөрийн чадвараа эрт алдсан тохиолдолд түүний хүсэлтийг нь үндэслэн дотоодын сургууль, курсээр тусгай мэргэжил эзэмших сургалтын зардлыг төр хариуцна;

4/ хуульд заасан бусад баталгаа.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2,3 дахь заалтад хамаарах мэргэжлийн жагсаалт, нэмэгдэл хөлс, сургалтын зардал олгох журмыг Засгийн газар батална.

3. Олон улсын хэмжээний соёл, урлагийн наадам, уралдаан тэмцээн, үзэсгэлэн, номын яармагт оролцож, онцгой амжилт гаргасан соёлын ажилтан, уран бүтээлчдэд мөнгөн шагнал олгоно. Мөнгөн шагнал олгох журмыг Засгийн газар тогтооно.

/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

22¹ дүгээр зүйл. Соёлын хяналт

1. Соёлын хяналтыг соёлын улсын хяналтын алба, улсын байцаагч, бүх шатны Засаг дарга хэрэгжүүлнэ.

2. Соёлын улсын хяналтын алба нь соёлын тухай хууль тогтоомж, түүнтэй холбогдсон норм, норматив, дүрэм, журмын хэрэгжилт болон соёлын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавина.

/Энэ зүйлийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

23 дугаар зүйл. Соёлын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1. Соёлын хууль тогтоомж зөрчигчдөд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дор дурдсан захиргааны хариуцлага хүлээлгэнэ:

1/Соёлын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэлгүй соёлын үйл ажиллагаа эрхэлсэн бол иргэнийг 40000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-200000 төгрөгөөр торгож, үйл ажиллагааг зогсоох;

/Энэ заалтыг 2001 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон ба 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

2/ дайн, хүчирхийллийг сурталчилсан бүтээлийг түгээн дэлгэрүүлэх соёлын үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай иргэнийг 25000-50000 төгрөгөөр, байгууллагыг 70000-250000 төгрөгөөр торгох.

3/Энэ хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 30000-50000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгож, үйл ажиллагааг зогсоох.

/Энэ заалтыг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар нэмсэн/

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан захиргааны хариуцлагыг соёлын хяналтын улсын байцаагч ногдуулна.

/Энэ хэсгийг 2002 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Н. БАГАБАНДИ